



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2022. 12. 23 № А-7/1320
танай _____-ны № _____-т

Зөвшөөрлийн тухай

Танай байгууллагаас 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 699 тоот албан бичгээр ирүүлсэн “F карт” төлбөрийн карт гаргах зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, түүнд нийцүүлэн баталсан журамд заасны дагуу хянаж үзлээ.

Албан бичгийн хавсралтаар ирүүлсэн баримт бичгүүд нь Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Монголбанкнаас батласан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журамд заасан шаардлагыг хангасан тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А-356 дугаар тушаалаар танай байгууллагад “F карт” төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргах зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаатай олгосныг үүгээр мэдэгдэж байна. Өөрийн оноосон нэрээр “F карт” гаргахдаа 949632 дугаартай БИН дугаарыг ашиглахыг зөвлөж байна.

Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж ажиллана гэж итгэж байна.

Хавсралт 1 хуудастай.

ТӨЛБӨР ТООЦООНЫ ГАЗРЫН
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХЭЛТСИЙН ЗАХИРАЛ



А.БАТСАЙХАН

1522024218



МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2022 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А-356

Улаанбаатар хот

Төлбөрийн хэрэгсэл гаргах
зөвшөөрөл олгох тухай

Төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-266 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, систем ажиллуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын 5.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ардкредит ББСБ ХК-нд “F карт” төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 4 (дөрөв) жилийн хугацаагаар олгосугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Төлбөр тооцооны газар (Э.Анар)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1522012513